

ТАНЫ НЭГ САРЫН
ХЭРЭГЛЭЭНД

166,580 ТӨГРӨГ

ХАНГАЛТТАЙ ЮУ?

- Монгол Улсын хүн амын **1/3** нь хүнсний болон хүнсний бус хэрэглээндээ сард **166,580-аас доош төгрөг** зарцуулж байна.

ЯДУУРАЛ


$$28.4\% + 14.9\% = ?$$

Ядуу хүн амын хувь

Ядууралд өртөх эрсдэлтэй хүн амын хувь

- Хотын хүн амын **27.2%** нь ядуу,
хөдөөгийн хүн амын **30.8%** нь ядуу байна.
Ядуу хүн амын **63.5%** нь хотод амьдарч байна.

ХҮН АМЫН НИЙТ ХЭРЭГЛЭЭ, АМЬЖИРГААНЫ 5 БҮЛГЭЭР



ЯДУУРЛЫН ТҮВШИН ГЭЖ ЮУ ВЭ?

Ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулна. Тухайлбал, 2018 оны байдлаар Монгол Улсын ядуурлын түвшин 28.4% байна.

ЯДУУРЛЫН ШУГАМ

Ядуурлын шугам нь хүний эрүүл, идэвхитэй амьдралыг хангахуйц илчлэгтэй хоол тэжээлийг худалдан авах болон хүнсний бус зайлшгүй хэрэглээг хангахад шаардагдах зардалд үндэслэнэ. Ядуурлын шугам нь ядуу хүнийг ядуу бус хүнээс ялгах гол шалгуур үзүүлэлт бөгөөд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амыг ядуу гэж үзнэ.

Ядуурлын шугамыг нэг хүнд 1 сард ногдох хүнсний болон хүнсний бус наад захын хэрэглээний зардлын дүнгээр тооцно. Монгол Улсын хувьд 2018 оны ядуурлын шугам 166,580 төгрөгөөр тогтоогдсон байна.

ӨГӨГДЛИЙН ТУХАЙ

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон Дэлхийн банк хамтран Монгол Улсын ядуурлын үзүүлэлтүүдийг 2 жил тутам тооцож зарладаг. Ядуурлын үзүүлэлтүүдийг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэлд үндэслэн тооцдог.

2018 оны ядуурлын үзүүлэлтүүдийг зарласан огноо: 2019/06/21